

хэлэлцээд батлуулаад мөрд¹. Энэ ажилд байгууллагын гишүүн бүрийг идвэхтэй оролцуулж үнэлэж дүгнэж хэвших шаардлагтай. Мөн судлаачид японы 5 С-ийн загварыг зөвлөдөг байна. Монгол хэлэнд буулгавал сайн ангилан ялгах, сайтар цэгцлэн зохион байгуулах, сайхан цэвэрлэж цэмцийлгэх, стандартчилан хэвшүүлэх, сахилга батыг төлөвшүүлэх гэсэн утгатай юм. 5С хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хамгийн өндөр бүтээмжтэй хамт олон төдийгүй хамгийн бүтээмжтэй байгууллага болох анхны алхам болно гэж ойлгож болно. 5С хөтөлбөрөөр дамжуулан ажилчдыг идэвхжүүлж, сургаж, 5С-ийг практикт хэрэглэснээр зөвхөн ажлын байрыг сайжруулаад зогсохгүй ажилчдын ажилдаа хандах хандлагыг өөрчилж, илүү бүтээлч, бүтээмжтэй байгууллага бий болгох юм. Мөн байгууллагын уур амьсгал сайжраад зогсохгүй байгууллагын соёлыг төлөвшүүлдэг².

Дүгнэлт.

Удирдагч хүний эрхэмлэж явах зүйл бол хов яриа, цуурхалыг дэврээлгүй дарж байх явдал юм. Гэхдээ хов яриа, цуурхал бүрийн араас мөрдөж цаг хугацаа зарцуулах нь үр дүн багатай болов уу. Харин хамт олны уур амьсгалыг өөрчлөх тэдэнд нэгдмэл зорилго зорилтыг нь ойлгуулж өгөх. Менежментийн мэдлэгээ дээшлүүлэн аливаа буруу хандлагаас урьдчилан сэргийлж ажиллах нь үр дүнтэй байх юм.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн 811 дүгээр дамжааны сонсогч,
цагдаагийн ахмад Б.Эрдэнэхүү*

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Хураангуй. Өнөөгийн шүүхийн шинжилгээний байгууллагын төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагаанд хийх өөрчлөлт, шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, гадаадын бусад улс орны туршлагыг нэвтрүүлэн хөгжүүлэх шаардлага тулгарч байна.

Түлхүүр үгс. Шүүхийн шинжилгээний байгууллага, хөгжил, шинэчлэлт, чиг хандлага.

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 63 дугаар тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Шүүхийн шинжилгээний үндэсний төвийг (2009 оноос Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нэртэй болсон) байгуулсан.^{1 2}

¹ biznetmork.mn

² Н.Цэнд, Г.Батхүрэл, Я.Шуурав. Менежмент сурах бичиг. УБ. 2013.

Мөн 2007 оны 270 дугаар тогтоолоор аймгийн цагдаагийн газар, хэлтсийн криминалистикийн шинжээч, аймгийн нэгдсэн эмнэлгийн шинжээч эмч нарыг нэгтгэн аймгийн шүүхийн шинжилгээний алба, нийслэлийн дүүргүүд, Замын цагдаагийн газар, Төмөр замын цагдаагийн хэлтсийн криминалистикийн шинжээчдийг нэгтгэн Нийслэлийн шүүхийн шинжилгээний албыг байгуулахаар шийдвэрлэжээ. Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг жил гаруйн хугацаанд хангасны үр дүнд 2009 оны 1 сарын 1-ний өдрөөс аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албыг Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн статустайгаар байгуулсан нь дэлхийн өндөр хөгжилтэй орны жишигт нийцсэн ололт амжилт болсон юм.

Гадаадын өндөр хөгжилтэй улс орны Шүүхийн шинжилгээний байгууллага нь улс орныхоо нийгмийн бүхий л салбарт үйл ажиллагаагаа явуулдаг. Хууль сахиулах чиг бүррэг бүхий байгууллагаас гадна төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн салбарт ч үйл ажиллагаа явуулах зарчмаар биеэ даасан бусад шинжлэх ухаантай салшгүй холбоотой өргөжин хөгжиж иржээ.

АНУ нь шүүх шинжилгээний олон жилийн туршлагатай бөгөөд анхнаасаа холбооны улс болон бүрдсэн учраас муж бүрт алба анх үүссэн байна. Мөн улмаар АНУ-ийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг байгууллага (*Нууц алба-Secret service, ХМТ-FBI, Архи, хар тамхи, галт зэвсэг, тэсрч дэлбэрэх бодистой тэмцэх алба-ATF, Эмийн бодист хяналт тавих алба-DEA*) бий болсноор холбооны улсын хэмжээний лабораториуд байгуулагдсан байна. Үүний хажуугаар олон төрлийн бизнесийг дэмждэг энэ улсад хувийн шүүх шинжилгээний лаборатори, бие даасан шинжээчид үйл ажиллагаа явуулах болсон.

2013 онд Хууль зүйн департамент болон Үндэсний стандарт, технологийн газар харилцан ойлголцох санамж бичигт гарын үсэг зурсан бөгөөд Үндэсний шүүх шинжилгээний комиссыг байгуулсан байна. Энэ байгууллагыг Холбооны зөвлөх хорооны хуулийн дагуу Хууль зүйн департамент байгуулж Үндэсний стандарт, технологийн хүрээлэн болон Хууль зүйн департамент хамтран 2 талаас нийт 30 комиссын гишүүнийг томилсон байна. Үндэсний шүүх шинжилгээний комиссын дэргэд шүүх шинжилгээний салбарууд болох ДНК, Баримт бичиг судлал, хар тамхи, хор судлал, гал болон тэсрэх бодис, галт зэвсэг, гарын мөр гэх мэт 21 ажлын хэсэг байгуулагдан нэгдсэн стандарт, шинжилгээний арга аргачлал боловсруулахаар ажилладаг.

БНСУ-ын хамгийн том шүүх шинжилгээний хүрээлэн болох Аюулгүй байдал болон нийтийн захиргааны яамны дэргэдэх Шүүх

шинжилгээний алба анх 1955 онд Дотоод явдлын яамны дэргэд байгуулагдаж байсан бөгөөд бүх төрлийн шүүх шинжилгээ, түүн дотор шүүх эмнэлэг, ДНК-ийн шинжилгээ хийдэг төв байгууллага юм. Солонгосын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Үндэсний тоон шүүх шинжилгээний төв нь тоон шүүх шинжилгээний, бичиг баримтын шинжилгээний, галын шинжилгээний, ДНК, сэтгэл судлал, полиграфын, дуу авианы лабораторитай байна. Үндэсний цагдаагийн газрын Эрүүгийн мөрдөх товчооны дэргэдэх Шүүх шинжилгээний, Гарын хээний, Шүүх биологийн шинжилгээний хэлтэстэйгээс гадна хэргийн газрын үзлэгийн багтай байна.

Үүнээс харахад Шүүхийн шинжилгээний төв байгууллага нь хөндлөнгийн хяналтын чиг үүрэгтэй бусад шүүхийн шинжилгээний байгууллагын өдөр тутмын ажиллагаанд оролцдоггүй зөвхөн мэргэжлийн удирдлагаар хангаж ажилладаг зарчимд шилжин өөрчлөгдөж байгаа юм. Энэ нь шүүхийн шинжилгээний байгууллагыг дэлхий нийтийн чиг хандлагад нийцсэн хяналтын чиг үүрэгтэй чадварлаг цомхон мэргэжлийн байгууллага болох нийгмийн шаардлага гарч байгааг илтгэж байна.

Манай улс гадаадын шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоонд байдаг жишгээр цагдаа, тагнуул, авлигал, мөрдөх алба, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн, онцгой, иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөн, прокурор болон батлан хамгаалах, хувийн хэвшилд өөрсдийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэх болох тодорхой төрлийн шинжилгээ, үзлэг хийдэг шүүх шинжилгээний бүтэц, лабораторийг байгуулахын зэрэгцээ улсын хэмжээний нэгдсэн төв шинжилгээний байгууллага байх нь зүйтэй юм.

Монгол Улсад барилга, авто замын материал, хүнс, хүн ба малын эмийн бэлдмэл ямар ч хяналтгүйгээр зах зээлд нийлүүлэгдэж байгаа нь орны аюулгүй байдал ноцтой зөрчигдөж байна.

Энэ асуудал дээр мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавьж ажилладаг боловч санаатай болон санамсаргүй олон буруутай үйл ажиллагаа гаргадаг нь байнга шүүмжлэлд өртдөг.

Барилга барих үйл явцад хүний амь нас үрэгдэх, улсын комисс хүлээн авах барилга дээр стандартын бус материал ашиглах, орц найрлагад нь өөрчлөлт хийх, замын ажлыг стандартын бус аргаар тавих зэрэг асуудал ихээр гарч байгаа хэдий ч хяналт тавих үүрэг бүхий албан байгууллага, албан тушаалтан хариуцлага үүрдэггүй. Энэ нь давхар хөндлөнгийн хяналтын чиг үүрэг бүхий шинжилгээний байгууллага байхгүй байгаа нь учир дутагдалтай байна.

Өнөөгийн нөхцөлд Геологийн төв лаборатори, Мэргэжлийн хяналтын газрын төв лаборатори, төрийн болон төрийн бус 112 байгууллагын лабораторид шинжилгээ хийгдсэн байдаг боловч тус лабораторийн гаргасан акт, үнэлэлт, дүгнэлт, магадлагаа нь шүүхийн шинжилгээний арга зүйгээр хийгдээгүй шүүхэд нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх боломж байхгүй.

Түүнчлэн Манай улсад эргэлзээтэй, маргаантай шинжээчийн дүгнэлтийг нэг байгууллагаар дахин хийлгэдгээс хүндрэлтэй асуудал байнга тулгардаг.

Нэг шинжилгээг ганц байгууллага хийдэг нь олон улсын жишигт нийцэхгүй хоцрогдсон арга барил болох нь судалгааны явцад илт ажиглагдаж байна.

Иймд дээд шатны шинжилгээний төв байгууллага эсвэл мэргэжилтэн шинжээчийн профессорын орон тооны болон орон тооны бус зөвлөлийн дүгнэлтээр шийдвэрлэж болох боломжтой.

Энэ шинжээчийн зөвлөл нь чиглэл бүрийн нарийн мэргэжлийн, чадварлаг, шударга, хараат бус, орчин үеийн дэвшилтэд техник технологиор хангагдсан бие даасан, хөндлөнгийн чиг үүрэгтэй байвал зохино.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн суралцагч,
цагдаагийн дэд хурандаа А.Бат-Амгалан*

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Хураангуй. Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын чиг үүрэг хамтын ажиллагааг сайжруулах арга замыг тодорхойлоход оршино.

Түлхүүр үг. Үндэсний аюулгүй байдал, хамтын ажиллагаа, хууль сахиулах байгууллага.

2010 онд шинэчилэн баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон гадаад бодлогын үзэл баримтлалд шинэ нөхцөлд аюулгүй байдлаа хангах зарчмыг хуульчилсан.

Бодлогын дээрхи баримт бичигт 1992 онд батлагдсан Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хуулийн үзэл санаанд тулгуурласан түүнийг хэрэгжүүлэх арга зам стратегийг тодорхойлсон.

Үзэл баримтлалд “Даяаршил улс үндэсний бусдаас хамаарах эмзэг байдлыг нэмэгдүүлж, нөгөө талаас гадаад нөөц боломжийг ашиглан